



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

20 ~~25~~ оны ⁰⁴ сарын ²⁸ -ны өдөр

№ ⁰¹

Дархан хот

Компанийн 2024 оны санхүүгийн тайлан,
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн
гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, "Монгол алт" ХК-ийн дүрмийн 8.4.9 дэх заалт, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын 01 дүгээр тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол алт" ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн тайланг баталсугай.

2. Тус компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд, Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.АМАРСАНАА



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 04 сарын 28-ны өдөр


№ 02

Дархан хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны зардлын төсөв, дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, "Монгол алт" ХК-ийн дүрмийн 8.7 дахь хэсэг, Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол алт" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хэвийн үйл ажиллагаа хангах 2025 оны зардлын төсвийг 21,120,000 (хорин нэгэн сая нэг зуун хорин мянга) төгрөгөөр тогтоосугай.
2. "Монгол алт" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүдийн урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА   Д.АМАРСАНАА

“Монгол алт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2025 оны
04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ**

№	ТУЗ-ийн гишүүний нэр	1 сарын урамшуулал /төг/	1 жилийн урамшуулал /төг/
1	Ердийн гишүүн ТУЗ-н дарга	200000	2400000
2	Ердийн гишүүн	180000	2160000
3	Ердийн гишүүн	180000	2160000
4	Ердийн гишүүн	180000	2160000
5	Ердийн гишүүн	180000	2160000
6	Ердийн гишүүн	180000	2160000
7	Хараат бус гишүүн	180000	2160000
8	Хараат бус гишүүн	180000	2160000
9	Хараат бус гишүүн	180000	2160000
10	Нарийн бичгийн дарга	120000	1440000
	Нийт		21120000

оОо



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 04 сарын 28-ны өдөр

№ 03

Дархан хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8, 46.10 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2.7 дахь заалт, "Монгол Алт" ХК-ийн дүрмийн 22.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дугаар сарын 28-ны өдрийн хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд 370 (гурван зуун дал) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.

2. Ногдол ашгийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар зуучлуулан 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тараалгахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.АМАРСАНАА